

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.01.26	A/22	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.02.01	A/32	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2023.02.01	A/33	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2023.02.01	A/35	Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн хөрөнгийг буцаан олгох тухай	
5	Аймгийн Засаг дарга	2023.02.01	A/42	Хөрөнгө зарцуулах тухай	
6	Аймгийн Засаг дарга	2023.02.07	A/55	Хөрөнгө зарцуулах тухай	
7	Аймгийн Засаг дарга	2023.02.07	A/56	Хөрөнгө зарцуулах тухай	
8	Аймгийн Засаг дарга	2023.02.07	A/58	Хөрөнгө зарцуулах тухай	
9	Аймгийн Засаг дарга	2023.02.10	A/65	Аймгийн хошой аварга малчин, аварга малчин, саальчин, фермер, тариаланч, тариаланч хамт олон, тэргүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж шалгаруулан шагнах тухай	
10	Аймгийн Засаг дарга	2023.02.15	A/72	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: **Б.Гантулга**



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/56

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 тогтоолоор баталсан Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардлаас 204,985,200 (хоёр зуун дөрвөн сая есөн зуун наян таван мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн "Хөвсгөл Ус Суваг" ХХК-д олгосугай.

2. Дээрх зардлын 204,985,200 (хоёр зуун дөрвөн сая есөн зуун наян таван мянга хоёр зуун) төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу Засаг дарга дансны "Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардал"-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Лхагважав)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

671010271



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/55

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 тогтоолоор баталсан Усны алдагдлын татаас 308,800,000 (гурван зуун найман сая найман зуун мянган) төгрөгийг аймгийн “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д олгосугай.

2. Дээрх зардлын 308,800,000 (гурван зуун найман сая найман зуун мянган) төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу Засаг дарга дансны “Усны алдагдлын татаас” зардлаас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Лхагважав)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/462

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд хоёр цэгт мөсөн гулгуурийн талбай байгуулах үйл ажиллагааны зардалд 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх дэмжлэгийн 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны Иргэд, байгууллагаас ирсэн хүсэлт шийдвэрлэх зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ) -т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

2



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/35

Мөрөн сум

Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн
хөрөнгийг буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалыг тус ус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн санд 2022 оны жилийн эцэст нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 31,489,332 (гучин нэгэн сая дөрвөн зуун наян есөн мянга гурван зуун гучин хоёр) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 4,128,500 (Дөрвөн сая нэг зуун хорин найман мянга таван зуун) төгрөгийг тухайн байгууллагуудад буцаан олгосугай.

2. Асрамжийн газрын 321.50 (гурван зуун хорин нэгэн төгрөг 50 мөнгө)-ийг орон нутгийн орлогод тооцугай.

3. Байгууллагуудын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 35,617,832 (гучин таван сая зургаан зуун арван долоон мянга найман зуун гучин хоёр) төгрөгийг буцаан олгож, 321,50 (гурван зуун хорин нэгэн төгрөг 50 мөнгө)-ийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710010110



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/33

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, залуучуудын нийгэм дэх үүрэг оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, амжилт ололт, зөв үлгэр дуурайлал, зэрэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор оны онцлох хүүхдүүдийг жил бүр шалгаруулж, Засаг даргын нэрэмжит мөнгөн урамшуулал олгох журмын дагуу аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн саналыг харгалзан оны онцлох амжилт бүхий хүүхэд, анги, хамт олныг шалгаруулж, хавсралтаар шагнаж урамшуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН


6710010097

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар
сарын 01 -ны өдрийн /133/ дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ МӨНГӨН УРАМШУУЛАЛ
АВАХ 2022 ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД, ХАМТ ОЛНЫ ЖАГСААЛТ

№	Хүүхэд, хамт олны нэр	Сум, сургууль	Шалгарсан төрөл	Онцлох урамшуулал /Төрөг/	Дансны дугаар	Харилцах утас
1	Э. Мөнхзул	Мөрөн сумын ЭДЦС, 12а анги	Техник сэтгэлгээ, шинэ санал, санаачилга, бүтээлч байдал	1 000 000	5914265396 /Өөрийн/	88507299
2	Б. Дөлгөөнмөрөн	Мөрөн сумын ДМЦС, 11б анги	Сурлагын амжилт	1 000 000	4905117185 /Өөрийн/	88683411
3	Д. Отгонтүвшин	Мөрөн сумын Авъяас ЕБС, 11а анги	Урлаг, уран бүтээл	1 000 000	5916441123 /Өөрийн/	80322992
4	Ү. Мягмарбаяр	Мөрөн сумын Титэм ЕБС, 10а анги	Биеийн тамир, спорт	1 000 000	5890560914, /Ээж Тунгалаг/	94629281
5	Ү.Эмүжин	Тосонцэнгэл сумын ЕБС, 3б анги	Эх орон, түүх уламжлал	1 000 000	5077165876 /Ээж Л.Ууганжаргал/	98116041
6	Б.Доржханд	Мөрөн сумын ДМЦС 12а анги	Байгаль хамгаалал, эрүүл, аюулгүй орчин	1 000 000	5916054586 /Ээж Ц.Жавзанпагма/	89386931
7	Б.Буянбаяр	Тариалан сумын ЕБС, 8а анги	Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс	500 000	5900136487 /Ээж Н.Дуламсүрэн/	88507299
8	Б.Энхбаяр	Тариалан сумын ЕБС 8а анги	Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс	500 000	5900128206 /Г.Болорцэцэг/	88683047
9	Б.Уламбаяр	Мөрөн сумын "Сод-Эрдэм" ЕБС, 11б анги	Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллага	1 000 000	5916396371 /Өөрийн/	86782919
10	Н.Төгсбат	Мөрөн сумын Титэм ЕБС, 9д анги	Тусгай хэрэгцээт боловсрол	500 000	5901108276 /Ээж Оюунгэрэл/	90010080

11	Г.Оюунжаргал	Мөрөн сумын Ирээдүй XXI зуун ЕБС, 10б анги	Тусгай хэрэгцээт боловсрол	500 000	5892207082 /Ээж Ж.Галхүү /	98987022
12	Д.Пунцагбалжир	Мөрөн сумын ЭДЦС, 12а анги	Багийн амжилт	1 000 000	5890596179 /Өөрийн/	88507299
13	Ү.Энхжин	Тосонцэнгэл сумын ЕБС, 12а анги	Эх орон, түүх уламжлал /Улсын/	2 000 000	5077165876 /Ээж Л.Ууганжаргал/	98116041



Handwritten signature

_____оОо_____



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.1.5, 19.1.6, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа”-ны зардалд 35,000,000 (гучин таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Уг зардлыг Засаг дарга ерөнхий дансны “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэг”-ийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.

3. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН



6717010339



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/22

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оныг "Хөвсгөлд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд 17,052,778 (Арван долоон сая тавин хоёр мянга долоон зуун далан найман) төгрөг, өвлийн аялал жуулчлалын чиглэлээр контент бүтээхэд 9,500,000 (Есөн сая таван зуун мянган) төгрөг, олон нийтэд сурталчлахад 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 39,862,778 (гучин есөн сая найман зуун жаран хоёр мянга долоон зуун далан найман) төгрөгийг Засаг дарга дансны "Хөвсгөлд зочлох жил нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал"-аас гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Хуваарилагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зориулалтын дагуу зарцуулж, баримтын бүрдлийг ханган ажлын тайлан мэдээг 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН